

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Ордын физик газарзүй	3
1.1.1. Цаг агаар	3
1.1.2. Уул зүй	3
1.2 Алтны шороон ордын ашиглалтын үйл ажиллагаа	4
1.2.1. Шимт хөрс хуулах ажиллагаа	4
1.2.2 Хөрс хуулалтын ажил	5
БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
2.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	5
2.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж	7
болзошгүй гол сөрөг нөлөөлөл	7
.....	8
2.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч	9
хэрэгжүүлсэн арга хэмжээ	9
2.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	10
БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
3.1. Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	11
3.1.1 Техникийн нөхөн сэргээлтийн зардалын тооцоо	11
.....	13
БҮЛЭГ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
7.1 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	16
БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
8.1. Шингэн хог хаягдал	18
8.2. Хатуу хог хаягдал	20
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
9.1 Орчны тохижилт болон ногоон байгууламж	21
БҮЛЭГ 10. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	22
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БИЕЛЭЛТ	23
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	24
БҮЛЭГ 13. ДҮГНЭЛТ	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №.1 Агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн бууруулахад хийгдсэн ажил	6
Хүснэгт №. 2 Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ	7
Хүснэгт №.3 Газрын гадаргад нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хийгдсэн ажил	9

Хүснэгт №.4 Нөхөн сэргээлтийн зардлын тооцоо	11
Хүснэгт №.5 Шимт хөрсийг ачих ажлын зардал	12
Хүснэгт №.6 Шимт хөрсийг тээвэрлэх ажлын зардал.....	13
Хүснэгт №.7 Дүйцүүлэн хамгаалах талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн зардал.....	14
Хүснэгт №.8 Осол эрсдэлийн менежментийн хүрээнд хийгдсэн ажлууд	15
Хүснэгт №.9 Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд	17
Хүснэгт №.10 БО-ны менежментийн төлөвлөгөөг танилцуулсан зардал.....	23
Хүснэгт №.11 БОМТ-ний төлөвлөгөөний тайланг хэлэлцүүлсэн хуваарь	24
Хүснэгт №.12 БОМТ-ийн биелэлтийн зардал.....	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №.1 Ус усалгааны машин.....	6
Зураг №.2 Хаягдал саарал ус болон ахуйн усны дээжлэлт авч шинжүүлэв.....	8
Зураг №.3 Унд ахуйн усны эх үүсвэрийг хамгаалж, худгийг тоолууржуулж лац тавиулсан.....	8
Зураг №.4 Агаарын тоосжилт болон орчны тохижилтонд зориулж мод тарьсан.....	10
Зураг №.5 Техникийн нөхөн сэргээлт хийж буй фото зураг.....	13
Зураг №.6 ШТМатериалыг битүүмжлэлтэй саванд хадгалж байгаа нь.....	16
Зураг №.7 Тамхи татах цэгүүд.....	18
Зураг №.8 Ашигласан тос маслыг дахин боловсруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч байна.....	19
Зураг №.9 Шатах тослох бүтээгдэхүүн асгарах үед авах арга хэмжээний зөвлөмжийг байрлуулсан	19
Зураг №.10 Хатуу хог хаягдалыг ангилан ялгах цэг.....	20
Зураг №.11 Засварын талбай.....	20
Зураг №.12 Уурхайн кемпийн тохижилтод зориулж цэцэг тарьсан.....	22
Зураг №.13 Уурхайн кемпийн тохижилтод зориулж мод тарьсан.....	22

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД:

- Ордын нөхөн сэргээлтийн ажлын зураг
- Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл
- Хог хаягдлын гэрээ
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн 2023 оны 05, 08 дугаар сарын тайланг нүүр болон шинжилгээний хариунуудын хуулбар хувийг хавсаргав.
- Шинжилгээний хариу

БҮЛЭГ 1. 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэх талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Бумбат-1” нэртэй “Дунд наймганы хөндийн” алтны шороон орд юм.

Ашигт малтмал ашиглалтын MV-021470 тоот тусгай зөвшөөрөлтэй “Дунд наймганы хөндий” ордод алтны шороон ордод “ИЛТ ГОУЛД” ХХК 2022 оноос эхлэн ашиглалт болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байна.

“Дунд наймганы хөндийн” алтны шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг тогтоож, технологийн шийдлийг зөв сонгон хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй дагаж мөрдөх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргийг уурхай ашиглах техник-эдийн засгийн үндэслэл дээр үндэслэн холбогдох хууль эрхийн бичиг, норм дүрэм, стандарт, заавар журам зэргийн дагуу боловсруулсан.

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээд давхаргын 1-С, 2-В, 3-В, 4-В, 5-В, 6-В, 13-В, 14-В, 15-В, 16-В, 17-В, 18-В, блокууд нийт 8.73 га талбайг олборлолтонд өртөх бөгөөд 407.71 мян.м³ хөрс хуулж, дунджаар 192 мг/м³ агуулгатай 145.42 мян.м³ элс олборлон баяжуулахаар төлөвлөсөн ба 8.73 га талбайг эвдрэлд оруулах ба техникийн нөхөн сэргээлтээр 5.0 га талбайг нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж нийт **20 000 0000** төгрөг зарцуулахаар тооцоолсон.

1.1 Ордын физик газарзүй

1.1.1. Цаг агаар

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн 1-р сард агаарын хэм 37⁰, хамгийн дулаан 7-р сард агаарын хэм +32⁰ хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% нь зун бороо байдлаар ордог. Өвөл 5-25 мм цасан бүрхүүл тогтож, хөрсний хөлдөлтийн гүн 2-5 м хүрдэг. Голчлон баруун хойноосоо 5-10 м/сек хурдтай салхилах ба зарим тохиолдолд 20 м/сек хүрдэг.

1.1.2. Уул зүй

Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой. Хамгийн өндөрлөг цэг нь далайн төвшнөөс 1815 м-т байрлах Цагаан уул. Хамгийн нам дор газар нь талбайн төв хэсэгт - 1040 м. Харьцангуй өндөржилт нь Дунд наймганы хөндийн хамгийн ойр орших өндөрлөгтэй холбож үзэхэд 150-200 м-т хэлбэлзэнэ. Уул нуруудыг зааглаж буй хотгорууд нь сул хэрчигдсэн 950-1100 м өргөгдсөн гадаргуунууд бөгөөд зүүн хойш чиглэлтэй, 4-7 км-ийн өргөнтэй.

1.1.3. Ус зүй

Усан сүлжээний хувьд хамгийн том гол нь Орхон голын баруун гарын цутгал болох 600 км орчим урттай, 1.0-4.0 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Гольдрол нь тохойрол, тахиралт ихтэй, олон тооны хар ус жижиг аралтай бөгөөд гольдролын өргөн 30-100 м, гүн нь 0.5-2.6 м хүрдэг. Туул голын баруун гар талын цутгал болох Дунд наймганы хөндий нь 7.0 орчим км урттай, 200-400 м дундаж өргөнтэй бөгөөд хайгуул гүйцэтгэсэн орд нь Дунд наймганы хөндийн дунд, дээд хэсэгт оршино.

1.2 Алтны шороон ордын ашиглалтын үйл ажиллагаа

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордод 2023 оны ашиглалтын үйл ажиллагаагаар 3.08 га талбай эвдрэлд орж, 9.24 мян.м³ шимт хөрс, 63.4 мян.м³ хөрс хуулалт хийж, 3.08 га талбайд техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэх нөхөн сэргээлтийг 5.0 га талбайд хийж гүйцэтгэсэн байна.

Уурхайн хөрс хуулалт болон нөхөн сэргээлтийн ажилд CAT-349 1ширхэг, БНХАУ-ын Автосамосвал HOWO-371 4 ширхэг, Бульдозер CAT-D8 1 ширхэг, БНСУ-ын Утгуурт ачигч SEM 650B 4-ширхэг, Угаах төхөөрөмж СБ-60 /монголд үйлдвэрлэсэн/ 1-ширхэг Усны машин DAEWOO 1 ширхэг, Түлшний машин, Суудлын машин Musso-2, Ажилчдын автобус-1 ширхэг, Ачааны машин 1-ширхэг зэрэг техникүүд ажилласан.

1.2.1. Шимт хөрс хуулах ажиллагаа

2023 онд MV-021470 лиценз бүхий ашиглалтын талбайн хэмжээнд 9.24 мян.м³ шимт хөрс хуулсан. Шимт хөрсийг ордын бүс нутгийн онцлог, хөрсний үржил шимээс хамааруулан 0.3м-ийн зузаантайгаар хуулж, бульдозерын тусламжтайгаар тухай бүрт нь шимт хөрсний овоолго үүсгэсэн. “Дунд наймганы хөндийн” алтны шороон ордын хөрс хуулалтын ажлыг явуулахдаа бага хэмжээний талбайд хөрсний овоолгыг байгуулж, газрын хөрс эвдрэх, ургамал дарагдах зэрэг сөрөг нөлөөллийг зохих хэмжээгээр багасгаж ажилласан.

Уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэхэд ордын ашиглалтын талбай орчмын ургамал, орчин тойрон нь ямар нэг байдлаар талхлагдлын нөлөөнд орох, овоолго хийх, уулын ажил явуулж буй техникийн хөдөлгөөний улмаас хөрс элэгдэл эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөтэй тул шимт хөрсийг нь хуулж тусад нь овоолго үүсгэж хадгалсан. Мөн техникийн үйл ажиллагааны улмаас тоос босох, дуу чимээ, утаа хорт хий гарах, овоолгын хөрс шороо салхинд хийсэн тархах, орчин тоосжих зэрэг сөрөг нөлөөллийг багасгахын тулд зам талбайг өдөр бүр тогтмол 2-3 давтамжтай усалж байсан. Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр шимт хөрсний найрлага, үржил шим нь алдагдахгүй сайн талтай юм.

Нийт хуулах үржил шимт хөрсний хэмжээ нь: $V = 3.08 * 10^4 * 0.3\text{м} = 9.240 \text{ м}^3$

1.2.2 Хөрс хуулалтын ажил

2023 оны ашиглалтын үйл ажиллагаагаар 7-В, 8-В, хэсэглэлүүдэд ашиглалтын үйл ажиллагаа явуулж 3.08 га талбай эвдрэлд орж, 9.24 мян.м3 хар шороон хөрс, 63.4 мян.м3 хөрс хуулалт ажил хийж дотоод овоолгоор хоосон орон зайд дүүргэлтийн ажил хийж хэлбэржүүлэн техникийн нөхөн сэргээлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын олборлох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед хөрс хуулалт, дотоод овоолго, хөрс элсний тээвэрлэлт, баяжуулалт, усан сан, бусад дэд бүтцийн барилга байгууламжуудын ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг товч тодорхойлов.

2.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны дагуу боловсруулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусга сан техник тоног төхөөрөмжүүдийг ашигласан.

Ашиглалтын үйл ажиллагаагаар уурхайн тоног төхөөрөмжүүдээс ялгарах хорт утаа болон тоосжилт үүснэ. Энэхүү хорт болон тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж буй талбайд дотоод овоолго, тээврийн хэрэгсэлийн дотоод зам талбайг тодорхой графикаар усалж чийглэж байсан.

Хөрс, хаягдлын овоолгыг ТЭЗҮ, БОНБНҮТайлан, Ашиглалтын үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэгт төлөвлөж тусгасан газар байрлуулж, шороон замыг аль болохоор усалгаа чийг хэрэглэн нягтаршуулж, уурхайн дүрэм журмын дагуу олон салаа зам гаргахгүйгээр, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулан байрлуулж, автомашин тээврийн хэрэгсэлийн хурданд хязгаарлалт хийж ажилласан.

Уурхайн замын тоосыг бууруулах үүднээс хайрга асгаж, замын суларсан шороог автогрейдерээр хусаж, усаар тогтмол усалж тоосыг дарж багасгах арга хэмжээ авч ажиллаж байсан.

Хөдөлгүүрт техникийн засвар үйлчилгээ, тохируулгыг тогтсон хуваарийн дагуу байнга үзлэг хийж, хүнд даацын машин механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж, жил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулж, моторын үйлчилгээг цаг тухай бүрд нь хийж багасгах арга хэмжээг авч ажилласан.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

2023 онд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Хүснэгт №.1 Агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн бууруулахад хийгдсэн ажил

№	Хийгдсэн ажил	Хариуцах эзэн	Жилийн төлөвлөгөө
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольсон болно.	Уулын инженер	250 мот/цаг тутам тээврийн хэрэгслийн моторын үйлчилгээг хийдэг.
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол усалсан.		Үйлдвэрлэлтийн зардалд туссан.
3	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлсэн.	Уурхайн дарга	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан байгаа.
4.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлсөн. Уулын ажилд хамрагдах 14 тээврийн хэрэгсэл ажилласан.		Агаарын бохирдлын төлбөр 133 000 төгрөг төлсөн.



Зураг №. 1 Ус усалгааны машин

2.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж**болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

MV-021470 тоот тусгай зөвшөөрөлтэй "Дунд наймганы хөндий" алтны шороон ордын талбайд байрлах баяжуулах үйлдвэр, үүсмэл нуурыг ашиглан үйл ажиллагаа явуулахаар ТЭЗҮ, БОНБНҮ-ний тайлан зэрэгт тусгасан байдаг. "Усны тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу усыг хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх, бохир ус цэвэрлэх технологийн горимыг мөрдөж ажилласан. Тунгаах сан байгуулж, технологийн усны 70-с доошгүй хувийг битүү эргэлтээр дахин ашиглах, усны нэвчилт, шүүрэлтийг багасгахын тулд угаах төхөөрөмжөөс гарч байгаа шлам шавраар нуурын ёроолыг хучих, далангийн шүүх чадварыг сайн болгох зэрэг арга хэмжээг авсан.

Элс угаах зорилгоор байгуулсан нуур цөөрмийн усны бохирдол нь газрын доорхи усанд шууд нөлөөлөх тул газрын доорхи усанд бохирдуулах бодис (хорт бодис, хог хаягдал, тос, шатахуун, бохир ус г.м) оруулахаас тогтмол урьдчилан сэргийлж ажилласан. Мөн далангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхэлгээ хийх, усан санг үер усны аюулаас хамгаалан суваг шуудуу татсан.

Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээнүүдийг авч унд-ахуйн усны эх үүсвэрт ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, журамлах, хэрэв ус тээвэрлэхэд хүрвэл зориулалтын машин болон ус хадгалах сав ашиглаж ажилласан.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж авч**хэрэгжүүлсэн ажил****Хүснэгт №. 2 Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ**

Д.д	Хийгдсэн ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан, төлбөр төлсөн.	Компанийн захирал	Уурхайн ашиглалт эхлэхээс өмнө хийсэн. Төлбөрийг төлсөн.
2	Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажилласан.	Уурхайн дарга	Бүсийн координат болон хотхон, ахуйн бохир, хог хаягдлын байршил харуулсан зураг гаргасан.
3	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэсэн.	Байгаль орчны мэргэжилтэн	2023 оны 05, 08 сард хяналт шинжилгээ хийлгэсэн болно.
4	Уурхайн технологийн усны хэрэглээг хянах зорилгоор ус татах шугаманд тоолуур тавьж баталгаажуулсан.	Байгаль орчны мэргэжилтэн	Туул голын сав газрын захиргааны мэргэжилтэн байлцаж тоолуур суурьлуулсан.

5	Унд ахуйн хэрэглээг хангах худагт хамгаалалтын бүс тогтоож, битүү бетон байшин барьж хамгаалсан.	Уурхайн менежер	Унд ахуйн худгийн орчмын бүс тогтоож амсар хэсгийг 2х2 метрын хэмжээтэй бетон цутгаж, байшин барьсан.
---	--	-----------------	---

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу орчны хяналт шинжилгээг 05, 08 сард 2 удаа хийлгэж технологийн цэвэр болон бохирын нуур, унд ахуйн худаг зэргээс усны дээж авч шинжилгээ хийлгэсэн. Стандартаас давсан үзүүлэлт байхгүй. Усны химийн шинжилгээ болон орчны хяналт шинжилгээний тайлангуудыг хавсаргав.



Хаягдал саарал ус болон унд ахуйн усны дээжлэлт
Зураг №. 2 Хаягдал саарал ус болон ахуйн усны дээжлэлт авч шинжлүүлэв.



Зураг №. 3 Унд ахуйн усны эх үүсвэрийг хамгаалж, худгийг тоолууржуулж лац тавиулсан

2.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

2023 онд MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордод ашиглалтын үйл ажиллагаагаар 3.08 га талбай эвдрэлд оруулж 3.08 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажил хийж аймгийн БОГ-ын нөхөн сэргээлт хүлээн авах комисст хүлээлгэн өгсөн.

Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

Хүснэгт №.3 Газрын гадаргад нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хийгдсэн ажил

Д.д	Хийгдсэн ажил	Хариуцах эзэн	Зардал сая.төг	Шалгуур үзүүлэлт
1	Газар эзэмших гэрээгээ Заамар сумын засаг даргатай байгуулах төлбөрөө төлсөн.	Компанийн захирал	Үйлдвэрийн зардалд оруулав.	Газрын гэрээ хийгдэж гэрчилгээг хүлээж байгаа.
2	Тэрбум модны ажлын хүрээнд 2000 орчим хайлаас, улиас, бургас модыг амжилттай үрслүүлэв.	Байгаль орчны мэргэжилтэн	5.0	-
3	Орчны тохижилтонд зориулж улиас, бургас ширхэгийг тарив. Мөн мандлын цэцэг ширхэгийг суулгав.	Байгаль орчны мэргэжилтэн	1.5	-
4	Ургамлын талхагдал болон хөрсний доройтолоос хамгаалж явган хүний замыг байгалын чулуугаар хийсэн байдаг. Мөн ажилчдаар ойр орчмын зэрлэг ургамлыг түүлгэн ургамын зүйлийг хамгаалдаг.	Байгаль орчны мэргэжилтэн	-	Ажилчдыг тогтмол зассан замаар явахыг шаарддаг, мөн байгаль хамгаалах өдөр болон мод тарих өдрүүдэд мод тарих хог түүлгэх болон зэрлэг ургамлыг зулгаах бүх нийтийн ажлыг зохион байгуулдаг.
5	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулсан.	Байгаль орчны мэргэжилтэн	0.5	Тогтмол хяналт тавьж болзошгүй эрсдэл гаргахгүй байх арга хэмжээ авч, сургалт явуулж, сурталчилж, тэмдэг тэмдэглэгээ байрлуулж ажилсан.
Нийт зардал сая.төг			7.0	



Зураг №. 4 Агаарын тоосжилт болон орчны тохижилтонд зориулж мод тарьсан.

2.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөлийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Заамар сумын нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг эзлэн орших Заамарын нуруу нь Их Хэнтийн нурууны үргэлжлэл бөгөөд хус, улиас, хар модон ойтой хангай хэнтийн бүсэд оршино. Тус бүс нутагт саарал чоно, халиу буга, үнэг, хярс, цагаан зээр, бор гөрөөс, тарвага зэрэг олон төрлийн амьтад нутагшина. Эдгээр амьтадыг хамгаалах ажлын хүрээнд хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байх нөхцөлийг хангаж ажиллаж байна.

Ажилчдад болон орон нутгийн иргэдэд амьтан, ургамал, байгаль орчны тухай сургалт, сурталчилгааг тогтмол явуулж ажилласан.

БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн ажлыг Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай, Газрын хэвлийн тухай зэрэг уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хуулиуд, холбогдох журам, стандартуудыг баримталж уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Техник болон дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг сум орон нутгийн Байгаль орчны мэргэжилтэн, Багийн засаг дарга, иргэдийн нийтийн хурлын гишүүдийн болон орон нутгийн төлөөлөл нарт танилцуулав. Мөн 2023.10.09-нд Аймгийн байгаль орчны нөхөн сэргээлтийг хүлээн авах коммист шалгуулж, хүлээлгэн өгөв.

3.1. Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордод 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан.

2023 онд MV-021470 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашиглалтын үйл ажиллагааг явуулсан бөгөөд 3.08 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Уурхайн техникийн нөхөн сэргээлтийг Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай, Газрын хэвлийн тухай холбогдох хууль, журам болон уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS5917:2008 стандарт зэргийг хангаж, нийцүүлэн хийхийг зорьж ажилласан.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг дотоод овоолгоор дүүргэлтийн ажлыг хийж үүний дарааг бульдозер болон экскаватор, ковшоор хослолоор хөрсийг нягтаршуулах хэвгийжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

3.1.1 Техникийн нөхөн сэргээлтийн зардалын тооцоо

Ашиглагдсан орон зай, ухааш болон овоолгын гадаргуу хэвгийжүүлэн тэгшлэх

Хүснэгт №.4 Нөхөн сэргээлтийн зардлын тооцоо

Зардлын нэр	Томьёо	Тайлбар, бодолт
Хэлбэржүүлэлт хийх ажлын хэмжээ	$\sum V_i = S_i \cdot h \cdot k_c$	$\sum V_i = 3.08 \cdot 10\,000 \cdot 0.5 \cdot 1.3 = 20.020 \text{ м}^3$
Ашиглалтын бүтээл, $\text{м}^3/\text{цаг}$	$Q = 3600 \cdot V \cdot K_{\text{зн}} \cdot K_{\text{ца}} / t_m \cdot K_c$ v-бульдозерийн түрэх призмийн эзэлхүүн $K_{\text{зн}}$ - гадаргын налуу тооцох коэффициент $K_{\text{ца}}$ -цаг ашиглалтын коэффициент t_m -мөчлөгийн хугацаа K_c -сийрэгжилтийн коэффициент	$Q = 3600 \cdot 16 \cdot 1.25 \cdot 0.9 / 2 \cdot 90 \cdot 1.3 = 468 \text{ м}^3/\text{цаг}$
Мөчлөгийн хугацаа	$t_m = t_{\text{ач}} + t_{\text{ач.я}} + t_6 + t_{\text{х.я}}$ $t_{\text{ач}}$ -ачих хугацаа $t_{\text{ач.я}}$ -ачаатай явах хугацаа t_6 -тараах хугацаа $t_{\text{х.я}}$ -хоосон явах хугацаа	$t_m = 0.5 + 0.5 + 0.5 + 0.5 = 2$
Нийт ажиллах цаг	$T = V_i / Q \cdot K_{\text{ца}}$ $K_{\text{ца}}$ -цаг ашиглалтын коэффициент	$T = 20\,020 / 468 \cdot 0.9 = 38.49 \text{ цаг}$

Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт} = T * T_{ц} * 1.15 * P_{дт}$ T _ц -цагт зарцуулах түлшний норм P _{дт} -1л түлшний үнэ	$C_{дт} = 38.49 * 50 * 3530 = 6\,793\,485$ мян.төг
Сэлбэг	$C_{сэ} = XO_{бульд} * K * T / T_k$ XO _{бульд} -бульдозерийн үнэ K-сэлбэг тооцох хувь хэмжээ 1% T _к -жилд ажиллах нийт хугацаа	$C_{сэ} = 1021000.0 * 0.001 * 38.49 / 2400 = 16.37$ мян.төг
Элэгдэлийн зардал	$C_{эхш} = XO_{бульд} * H_э * T / T_k$ H _э -ЭХШ-ийн норм 10%	$C_{эхш} = 1021000 * 0.01 * 38.49 / 2400 = 163.74$ мян.төг
Нийт зардал	$C_{нийт} = 6\,793\,485 + 16\,370 + 163\,740 = 6\,973\,595$ төг	
1м ³ хэлбэржүүлсэн хөрсний өртөг зардал төгрөг	эзэлхүүн: $V_{хөрс.хуу} = C_{нийт} / V_{шх}$	$V_{хөрс.хуу} = 6\,973\,595 / 20\,020 = 348.33$ төг

Техникийн нөхөн сэргээлт хийсэн 3.08 га талбайн овоолгын гадаргууг хэвгийжүүлэх **20 020 м³** эзэлхүүн сийрэгжсэн хөрсийг хэвгийжүүлэн тэгшлэх үеийн зардлын дүн **6 973 595** төгрөг болж байна.

Шимт хөрс ачих, тээвэрлэх болон тараах ажиллагаа

2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 3.08 га талбайг шимт хөрсөөр хучих үеийн ажлын зардал.

Шимт хөрсийг ачих ажлын зардал

Хүснэгт №.5 Шимт хөрсийг ачих ажлын зардал

Үзүүлэлтийн нэр	Товч нэр	Дүн/мян.төг/	Томьёо
Шимт хөрсийг тээврийн хэрэгсэлд ачих ажлын зардал. /мян.төг/	Зач	2108.0	Зач = $V_{шх} * (a_э + a_э)$, төг
Тээврийн хэрэгсэлд ачих шимт хөрсний үеийн эзэлхүүн, м ³	V _{шх}	18 000	
Хадгалалгүйгээр шууд ачих зардал ба түр овоолгоос ачих зардал, төг/м ³	Аэ	116	
1м ³ шимт хөрс ачих ажлын өөрийн өртөг	эзэлхүүн: $V_{хөрс.ач} = Z_{ач} / V_{шх}$	$V_{хөрс.ач} = 2108.0 / 18000 = 0.117$ мян.төг буюу 117 төг/м ³	

Шимт хөрсийг тээвэрлэх ажлын зардал

Хүснэгт №.6 Шимт хөрсийг тээвэрлэх ажлын зардал

Үзүүлэлтийн нэр	Товч нэр	Дүн/мян.төг	Томьёо
Хөрс чулуулгийн нягт, т/м ³	Υ	1.5	$З_{тээв} = \sum V_i * \gamma * \alpha_{тээв} * L \text{ төг}$
Тээвэрлэлтийн зардал төг/тн-км	Атээв	220	
Тээвэрлэлтийн зай, км	L	0.4	
Эдэлбэр газрын / i / дугаартай хэсгээс тээвэрлэх хөрсний үеийн эзэлхүүн, м ³	V _i	18 000	
Шимт хөрсийг тээвэрлэх ажлын зардал /мян.төг/	З _{тээв}	2376.0	

Шимт хөрсийг ачиж, тээвэрлэн тараах үеийн зардлын дүн:

Нийт: 2108.0+2376.0 = 4 484.0 мян.төгрөг болж байна.

Нийт техникийн нөхөн сэргээлтийн ажилд:

Ашиглагдсан орон зай, ухааш болон овоолгын гадаргуу хэвгийжүүлэн тэгшлэх зардал Шимт хөрсийг ачиж, тээвэрлэн тараах үеийн зардал

Нийт: 6 973 595 +4 484.0= 11 457.595 мян.төг



Зураг №. 5 Техникийн нөхөн сэргээлт хийж буй фото зураг.

БҮЛЭГ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын 2023 оны Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалахаар Заамар сумын байгаль орчны хариуцсан улсын байцаагчийн зөвлөсөний дагуу 3.08га техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж, мод тарихаар төлөвлөсөн. Төв аймгаас зөвшөөрөл авч техникийн нөхөн сэргээлт хийх газрыг заалгаж Төв аймгийн Заамар сум Хайлааст багийн нутагт байрлах 5 га /нинжа нарын ухаж эвдрэлд оруулсан/ газарт техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. 2000 ширхэг бургас, хайлаас модыг кемп дээр тарьсан.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан тус газарт техникийн нөхөн сэргээлтийг бульдозер, экскаватор техникийн хослолоор хийгдсэн бөгөөд ухагдсан газрыг нөхөн дүүргэх овоолсон хөрсийг тараах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Уг техникийн нөхөн сэргээлтийн зардлыг аргачлалын дагуу тооцоолон гаргалаа.

Ашиглагдсан орон зай, ухаш болон овоолгын гадаргуу хэвгийжүүлэн тэгшлэх.

Хүснэгт №7 Дүйцүүлэн хамгаалах талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн зардал

Зардлын нэр	Томьёо	Тайлбар, бодолт
Хэлбэржүүлэлт хийх ажлын хэмжээ	$\sum V_i = S_i \cdot h \cdot k_c$	$\sum V_i = 5 \cdot 10\,000 \cdot 0.7 \cdot 1.3 = 45\,500 \text{ м}^3$
Нийт ажиллах цаг	$T = V_i / Q \cdot K_{ца}$ K _{ца} -цаг ашиглалтын коэффициент	$T = 45\,500 / 702 \cdot 0.9 = 58.3 \text{ цаг}$
Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт} = T \cdot T_{ц} \cdot 1.15 \cdot P_{дт}$ T _ц -цагт зарцуулах түлшний норм P _{дт} -1л түлшний үнэ	$C_{дт} = 58.3 \cdot 50 \cdot 3530 = 10\,289.950 \text{ мян.төг}$
Сэлбэг	$C_{сэ} = XO_{бульд} \cdot K \cdot T / T_k$ XO _{бульд} -бульдозерийн үнэ K-сэлбэг тооцох хувь хэмжээ 1% T _к -жилд ажиллах нийт хугацаа	$C_{сэ} = 1021000.0 \cdot 0.001 \cdot 48.1 / 120 = 409.25 \text{ мян.төг}$
Цалингийн зардал	$C_{ц} = T \cdot Ц_{ц}$ C _ц -Цалингийн нийт зардал Ц _ц -Машинист, жолоочийн, цагийн тарифт, цалин, мян.төг	$C_{ц} = 48.1 \cdot 7500 = 360.75 \text{ мян.төг}$
Нийт зардал	$C_{нийт} = 10\,289.950 + 409.25 + 360.75 = 11\,059.95 \text{ мян төг}$	

1м ³ хэлбэржүүлсэн хөрсний өртөг зардал төгрөг	эзэлхүүн: $V_{\text{хөрс.хуу}} = C_{\text{нийт}}/V_{\text{шх}}$	$V_{\text{хөрс.хуу}} = 11\,059.95/45\,500 = 243.07 \text{төг/м}^3$
---	---	--

Дүйцүүлэн хамгаалах талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн 5 га талбайн гадаргууг хэвгийжүүлэх **45 500.0м³** эзэлхүүн хөрсийг сийрэгжүүлэн хэвгийжүүлэн тэгшлэх үеийн зардлын дүн **11 059 950** төгрөг болж байна.

БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох талаар тусгагдаагүй болно. Энэ үйл ажиллагааны жил нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олголт хийгдээгүй болно.

БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордод 2023 оны үйл ажиллагааны явцад түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс, археологи, палеонтологи зэрэг дурсгалт зүйлс илрээгүй болно.

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл болон учруулсан хохирол осол эрсдэлгүй ажилласан. Хаягдал тос болон тос шатахуун асгаралтын үед авах арга хэмжээний талаар, хог хаягдлыг ангиалан ялгах, галын аюулын талаар, хэрхэн галыг унтраах зэрэг сургалтыг, мөн ковидын үед халдвар хамгаалалтын дэглэмийг сахих, халдварт өвчний үед зохион байгуулав. Сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй үйл ажиллагаа бүрт хяналт тавьж ажилласан.

Хүснэгт №.8 Осол эрсдэлийн менежментийн хүрээнд хийгдсэн ажлууд

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тос гоожилт асгаралт нэвчилт гарах үед	Тос шатахуун асгаралтын үед авах яаралтай арга хэмжээний талаар ажилчдад сургалт орох	Дунд наймганы уурхайн ажилчид	1	1	250.0	10 сард	ХАБЭА Дүрэм болон байгаль орчны журам баримтална

2	Галын аюулгүй байдал, гал гарсан үед авах арга хэмжээ	Галын аюулгүй байдал, гал гарсан үед хорыг хэрхэн зөв ашиглах талаар сургалт	Дунд наймганы уурхайн ажилчид	1	1	250.0	10 сард	ХАБЭА Дүрэм болон байгаль орчны журам баримтална
3	Халдварт өвчин	Ковидын үед баримтлах журам	Дунд наймганы уурхайн ажилчид	1	1	100.0	10 сард	Ковидын дүрэм журам баримтлах
Нийт						600.0		

7.1 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх зэрэгт анхаарч ажилласан. Шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс хайргаар хучилт хийж, тусгай тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.

Мөн нефтийн бүтээгдэхүүн нь органик нэгдлүүдийн нийлмэл бөгөөд хөрсөнд нэвчсэн тохиолдолд түүний гүнд ихээхэн хэмжээний бохирдлыг бий болгон удаан хугацаагаар хадгалагддаг онцлогтой. Ингэж бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж эсхүл бууц хольж асган саармагжуулалт хийнэ.



Зураг №. 6 ШТМатериалыг битүүмжлэлтэй саванд хадгалж байгаа нь

MV-021470 лиценз бүхий “Дунд наймганы хөндийн” алтны шороон ордын алт агуулсан баяжмалыг олборлон баяжуулахад усаар угаан хүндийн хүчний буюу гравитацийн аргаар баяжуулдаг учир ямар нэгэн химийн бодис хэрэглэх шаардлагагүй болно.

БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус уурхайн үйл ажиллагаанаас технологийн болон ахуйн хэрэгцээний хаягдал гарсан. Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлыг ялган ангилж Заамар сумын Хайлааст багын хогийн цэгт хаяж байсан.

Хүснэгт №.9 Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд

Д.д	Хог хаягдлын талаар хийгдсэн ажлууд	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ Заамар сумын засаг даргаар тогтоолгосон.	Компанийн захирал	Заамар сумын засаг дарга, БОХУБ-гчтай хог хаягдлын гэрээ байгуулсан.
2	Ахуйн хог хаягдлаа өөрийн техник тоног төхөөрөмж ашигласан.		Тийм
3	Хог хаягдлын төлбөрөө төлсөн.		Төрийн сан Заамар сумын ОНТатвар дансанд 300.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.
4	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлыг ялган ангилж Заамар сумын Хайлааст багын хогийн цэгт хаяж байсан.	Уурхайн дарга	Хайлааст багын хогийн цэгт хаяж байна.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг тусгай саванд төвлөрүүлж байна.		Уурхайгаас гарсан хаягдал тос маслыг тусгай саванд ялгаж хураан хөдөө аж ахуйн болон хоёдогч түүхий эд ашигладаг компанид нийлүүлдэг.
6	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэсэн.		Орчны хяналт шинжилгээг 08 сард хийлгэсэн.
7	Уурхайн ажилчидад: Улаанбаатараас уурхай болон Заамар сумруу зорчих зам дагуу хог хаяхгүй байх сургалт явуулсан.		Сургалт явуулж, сурталчилан таниулсан.
8	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийж байсан.		ХАБЭА-н ажилтан, Уурхайн эмч, Диспетчер, Байгаль орчны мэргэжилтэн нар хамтран хийж гүйцэтгэж байна.
9	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авч хэрэглэж байна.		Улаанбаатар хотоос ханган нийлүүлж байна.

10	Уурхайн хотхонд мод болон нүүрс ашигласан болно. Ихэнх хугацаанд цахилгаан хэрэглэдэг.		Гарсан үнсийг хогийн цэгт хаяв.
11	Дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаасан.		Дахин ашиглах түүхий эдийг ялган ангилж авдаг.



Зураг №. 7 Тамхи татах цэгүүд

8.1. Шингэн хог хаягдал

Уурхайн хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээ хийгдсний дараагаар сольсон тос масло, шүүр, ахуйн хэрэглээний бохирын ус гэх мэт хаягдал гарна. Техникийн засвар үйлчилгээг хийхдээ шингэнийг зориулалтын саванд тосж аван, шүүлтүүрийг хатуу хог хаягдал буюу төмрийн хаягдалд тусад нь байрлуулсан.

Зураг №. 8 Ашигласан тос маслыг дахин боловсруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч байна.



Шингэн хаягдал буюу тос маслыг зэрэгийг битүүмжтэй саванд хийж хадгалан “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК- ийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрт хаягдал тосыг 2023 онд 10.0 тонн хаягдал тосыг нийлүүлсэн байна.

Бусад хог хаягдлыг төвлөрсөн цэгт зохих журмын дагуу дарж булах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнээс гадна бие засах газрын битүүмжлэлийг сайн хийж, тогтмол ариутгал цэвэрлэгээ хийх арга хэмжээг авч ажилласан.



Зураг №. 9 Шатах тослох бүтээгдэхүүн асгарах үед авах арга хэмжээний зөвлөмжийг байрлуулсан.

8.2. Хатуу хог хаягдал

Уурхайн механик цех, токарийн суурь машин, засвар үйлчилгээ хийгдсэн машин механизмаас гарах хатуу хог хаягдлууд орно. Иймд уулын тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хураасан. Засвар үйлчилгээ хийх талбай, хатуу хог хаягдлыг хураах цэгийн байршлын зургийг доор харуулсан болно.



Зураг №. 10 Хатуу хог хаягдалыг ангилан ялгах цэг



Зураг №. 11 Засварын талбай

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Захиалагч: "Илт гоулд" ХХК

Шинжилгээ хийлгэсэн байгууллага: "Газарчандмань" ХХК

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэг чухал хэсэг байдаг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зохих стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хязгаарт байгаа эсэхийг хянах орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх удирдамж болдог.

Уг ажлын гол зорилго нь үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээг бүрэн тодорхойлж хянах, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг гаргахад оршдог.

“Илт Гоулд” ХХК нь “Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр”-ийг “Газарчандмань” ХХК-иар 2022 оны 05, 08-р саруудад хийж гүйцэтгүүлсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчин менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаар, ургамал, хөрсний шинжилгээнүүдийг хийсэн. Тус компани нь “Газар зүйн хүрээлэн”-ийн хөрс судлалын лабораторт шинжилгээнд оруулсан байна.

Ашиглалтын үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрт үзүүлэх аливаа сөрөг нөлөөлөл, түүнийг хянах хэлбэр, хяналт шинжилгээний зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд, сорьц дээж авах болон хэмжилт хийх цэгийн байршил, хяналт-шинжилгээ хийх хугацаа, давтамж, шинжилгээний арга аргачлал, шаардагдах зардал, шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах хэлбэр зэргийг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгаж ажилласан.

Орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ уурхайн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан, хээрийн хэмжилт дээжлэлтийг хийх ба үр дүнг тайлагнахдаа Монгол улсын холбогдох стандарттай харьцуулж үзэх, мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж зөвлөгөө авах, итгэмжлэгдсэн лабораториудаар шинжилгээ хийлгэх, эрх бүхий субъектээр дүгнэлт гаргуулах хэлбэрээр ажилласан.

“Газарчандмань” ХХК-ий 2023 онд хийсэн “Байгаль Орчин Хяналт Шинжилгээн”-ий ажлын тайланг хавсаргав.

9.1 Орчны тохижилт болон ногоон байгууламж

Уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэхэд газрын гадаргын хөрс элэгдэлд ордог тул уурхайчдын тосгонд мод, сөөг, цэцэг тарьж, тоос босохоос сэргийлж усжуулалтын системийг хэрэглэн, ажилчид явах тодорхой зурвас замуудыг бий болгож, уурхайн тосгоныг тойруулан хашаа барих зэргээр хөрсний элэгдлээс хамгаалах арга хэмжээнүүдийг тогтмол авч ажиллаж байсан. Уурхайн тосгоны тохижилтонд 2023 онд бургас-400 ширхэг, хайлаас-400 ширхэг мод тарьсан. Уурхайн кемпийн тохижилтонд зориулж нил цэцэг, шар хилэн, ягаан, цагаан, шар хун зэрэг нийт 1500ш цэцэг тарьж ургуулав.



Зураг №. 12 Уурхайн кемпийн тохижилтод зориулж цэцэг тарьсан.



Зураг №. 13 Уурхайн кемпийн тохижилтод зориулж мод тарьсан.

БҮЛЭГ 10. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

“Илт Гоулд” ХХК нь Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай, Газрын хэвлийн тухай зэрэг уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хуулиуд, холбогдох журам, стандартуудыг баримталж уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

2023 онд төрийн байгууллагаас ирсэн шаардлага байхгүй өмнөх жилүүдэд ирсэн шаардлагыг цаг тухайд биелүүлж, баримтжуулан холбогдох байгууллагад нь хүргүүлж заавар зөвлөгөөг авч ажилласан. Мөн орон нутгийн зам засах зэрэг ажлуудад удаа дараа алгалсалгүй оролцож ирсэн.

Мөн орон нутгийн иргэдийн амжиргааг дээшлүүлэх зорилгоор газар тариалан эрхэлж буй ажилчдад хүлэмж авч өгөх, хашаа барьж өгөх зэрэг ажлуудад санхүүгийн тусламжийг үзүүлж орон нутгийн иргэдтэйгээ уялдаа холбоотой ажилласан.

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БИЕЛЭЛТ

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримтлаж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон ИТА-чид хариуцаж ажилласан.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн

удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Хүснэгт №.10 БО-ны менежментийн төлөвлөгөөг танилцуулсан зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2 дох жил	Зардал. төг	Хариуцагч
		Нийт зардал		
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдүүлсэн болно.	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн дарга
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлж, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.	8 сард	1700.0	Уурхайн дарга
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын тайланг БОАЖЯ-ны ХБОНУГ болон Төв аймгийн БОАЖГ, Заамар сумын ЗДТГ-т жил бүрийн тайлагнаж ажиллаж байна.	07,10 сард	Дотоод төлөвлөлтөөр	Байгаль орчны мэргэжилтэн
4	Байгаль орчны хяналт шинжилгээний тайлан /“Газарчандмань” ХХК/	05, 08 сард	2 800.0	Байгаль орчны мэргэжилтэн

5	Аймаг нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	09 сард	2 000.0	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт		6 500.0		

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Хүснэгт №.11 БОМТ-ний төлөвлөгөөний тайланг хэлэлцүүлсэн хуваарь

Хугацаа	Олон нийтэд тайлагнах. танилцуулах ажлын жагсаалт	Зохион байгуулах хүний албан тушаал
2023 оны 11-р сард	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулж ажилласан. Төв аймгийн Байгаль Орчны Газарт 2023 оны Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайланг, талбайг хүлээлгэж өгсөн.	Байгаль орчны ажилтан. Уурхайн дарга

MV-021470 лиценз бүхий “Дунд наймганы хөндий”-н алтны шороон ордын 2023 оны байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн зардлын нэгтгэл.

Хүснэгт №.12 БОМТ-ийн биелэлтийн зардал

Д/д	Зардлын утга	Нийт зардал.мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	7000.0
2	Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардал	11 457.595
3	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	11 059.95
4	Осол эрсдэлийн менежментээр хийгдсэн ажлын зардал	600.0
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	300.0
6	Удирдлага зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	6500.0
Нийт зардлын дүн		36 917 545

БҮЛЭГ 13. ДҮГНЭЛТ

“Илт Гоулд” ХХК нь Ашигт малтмалын тухай, Байгаль орчны тухай, Газрын хэвлийн тухай зэрэг уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хуулиуд, холбогдох журам, стандартуудыг баримталж уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г хянуулж, батлуулан ажилласан. Уг төлөвлөгөөнд үйл ажиллагаагаар 10.16 га талбайг эвдрэлд оруулах ба техникийн нөхөн сэргээлт 5 га талбайг нөхөн сэргээхээр төлөвлөж байна..

MV-021470 лиценз бүхий "Дунд наймганы хөндий"-н алтны шороон ордын хэмжээнд техникийн нөхөн сэргээлтийг 3.08 га талбайд, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг Заамар сум Хайлааст багийн нутагт байрлах 5 га /нинжа нарын ухаж эвдрэлд оруулсан/ газарт техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Орчны хяналт шинжилгээний ажлыг “Газарчандмань” ХХК-иар 05,08 саруудад хийж гүйцэтгүүлж мэргэжлийн заавар зөвлөгөөг авч ажиллаж байна.

Хөрс, ус, агаарын шинжилгээг 05, 08 саруудад хийлгүүлсэн. Стандартаас давсан үзүүлэлт байхгүй. Бага зэрэг өсөлттэй байгаа үзүүлэлт шинжилгээний үр дүнд тулгуурлан сөрөг нөлөөллөөс үзүүлж болзошгүй үйл ажиллагаа бүрт хяналт тавьж ажилласан.

2023 оны байгаль орчны хамгаалах байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардалд нийт **36 917 545** төгрөг зарцуулав.